



413

**УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ  
ТОГТООЛ**

1962-5-24

№ 99

Улаанбаатар хот

*13-ийн 1990-ийн 140-ийн гүйцэтгэх зүйлс*

**Хянан байцаах тасгийн дүрмийг  
батлах тухай.**

**Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргаанаас  
ТОГТООХНЬ:**

**1. Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны хянан байцаах тасгийн дүрмийг 1962 оны 5-р сарын 20-ноос эхлэн үх түр дөгж мөрдөхөөр баталсугай.**

**Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргааны**

**дарга *Лувсанчой* ЛУВСАНЧОЙ МБОЛ**



**Хариуцлагатай нарийн бичгийн**

**дарга *Донров* ДОНРОВ**

5 % цо Ч.Б.

НИЙЛСЭН...

ХЯНАСЭН...

124

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-

ГААНЫ ХЯНАН БАЙЦААХ ТАСГИЙН ДҮРЭМ.

нэг. Ерөнхий зүйл.

1. Улаанбаатар хотын Гүйцэтгэх Захиргааны хянан ~~ийн~~ бэйцвэх тасег нь Улс хоршоололын хөрөнгийг үр ашиггүй зарч үрэгдүүлэгч, идэж шемшигдуулагчидтай тэмцэх, санхүү төсвийн сөхилгэ бат зөрчсөн дутардлыг илрүүлэн арилгах, хөрөнгийн арчилалт, бүртгэл тооцооны ажлыг сайжруулан аж ахуйн дотоодын нөөц бололцоог дүүрэн ашиглахын тулд үйлдвэр аж ахуйн гезер, албан байгууллагуудын санхүүд баримтын шалгалтыг байнга хийж байна.

2. Хянан байцаах тасег нь Улаанбаатар хотын Гүйцэтгэх Захиргааны даргын удирдлагын дор ажиллах бөгөөд өөртөө тусгай тэмдэгтэй байна. Хянан байцаах тасгийн бэйцаагч нар нь шалгалт бэйцаалт явуулах үедээ хотын Гүйцэтгэх Захиргааны даргын гарын үсэг бүхий шалгах эрхийн үнэмлэхтэй байна.

3. БНМА Улсын Сайд нарын Зөвлөл МАХН-ын Төв Хорооны 1960 оны 3-р сарын 25-ны өдрийн 125/71-р тогтоолын 3-р зүйлийн //в// //г// -д зөвсөн торгууль, төлбөрүүд болон албан <sup>кариуцаага</sup> захиуцаага алдсаны хувьд авах арге хэмжээг шалгалтын акт материалыг үндэслэн хотын Гүйцэтгэх Захиргааны даргын

захирэмжаар оногдуулна.

4. Шалгалтын акт болон Гүйцэтгэх Захиргааны шийдвэрийг шалгагдсан байгууллага заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд акт, дэвсгэвэр, захирэмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд нь хянан байцаах тасагт сэдгүй гаргах өгнө.

5. Хянан байцаах тасгийн шалгалтаар илэрсэн бөгөөд хөрөнгө мөнгийг ихээхэн хэмжээгээр ашиглан дутагдуулсан этгээдийн эцсийн акт гарахын өмнө түүний хөрөнгийг хамгаалуулах ба гэмт холбогдолтой акт материалыг прокурорын хяналтанд шилжүүлж байна.

Хоёр. Хотын Гүйцэтгэх Захиргааны хянан байцаах тасгийн үүрэг.

6. Орон нутгийн төсвөөр санхүүждэг соёл гэгээрэл Урлаг, эрүүлийг хамгаалах байгууллага болон засаг захиргааны байгууллагуудын төсөвт хөрөнгийн зарцуулалт, хөрөнгийн арчилалт, хамгаалалт эд хариуцлагчийн тооцооны байдал, батлагдсан орон тооцалингийн журмалт, санхүүгийн талаар гаргасан хууль, тогтоол, дүрэм зааварын биелэлтэнд баримтын шалгалт хийнэ.

7. Төсөвт байгууллагуудын төсвийн гадуурхи хөрөнгө, мөн цэцэрлэгт хүүхдээ хүмүүжүүлж байгаа эцэг эхээс хүүхдийн хосонлонд зориулж нийлүүлсэн мөнгөний хуралт ба зарцуулалт, бүртгэл тооцооны талаар баримтын шалгалт хийнэ.

8. Хотын худалдааны трестүүд, дэлгүүр, гуанаууд, хот нийгэм хангамжийн харьяа газрууд зэрэг хотын чанартай үйлдвэр аж ахуйн газруудын санхүүд баримтын шалгалт хийнэ.

9. Төсөв байгууллага ба үйлдвэр аж ахуйн газрууд дээр нягтлан бодох бүртгэлийн ажил зохиох зааварын ёсоор бүрэн хөтөлгөөнд байгаа эсэхийг шалгана.

10. Улсын банкны харьяа орон нутгийн хэлтэс салбаруудаас төсвийн орлого, зарлагын кассын төлөвлөгөөг хэрхэн биелүүлж байгааг шалгана.

11. Өөрийн хяналт шалгалтын аппарат бүхий байгууллагын санхүүгийн дотоодын хяналт шалгалтын ажиллагааг сайжруулахын тулд тогтмол төлөвлөгөөтэй шалгалт хийлгэж байх талаар зохих шаардлага тавьж ажиллуулахын хамт тэдний хяналт шалгалтын аппаратын хүмүүстэй хүч хамтэрч тэр байгууллагын харьяа газар байгууллага дээр шалгалт хийнэ.

3.

12. Хянан шалгах тасаг нь өөрийн шалгалт байцаалтын дүн ба нийт албан байгууллагуудын сөнхүү аж ахуйн ажиллагааг шалгасан дүнгийн талаар гүйцэтгэх захиргааны гишүүдийн хуралдаанд зохих асуудлыг оруулж байна.

Гурав. Хотын Гүйцэтгэх Захиргааны хянан байцаах тасгийн эрх.

13. Хянан байцаах тасаг, түүний байцаагч нар нь шалгагдаж байгаа байгууллагуудын мөнгөний баримт, нягтлан бодох бүртгэлийн данс, мэдээ болон төсөв, төлөвлөгөө, бусад баримт материалыг саадгүй гаргуулан авах эрхтэй, түүшлэн бэлэн мөнгө, үнэ бүхий цаас, эд материалын үнэт зүйлүүдийг биечлэн тоолж дансны үйлдэгдэлтэй тулгах ба мөн шалгах байгаа газарт нь холбогдолтой дансны хуулга, баримт, тодорхойлолыг банкны байгууллагууд буюу хоёр дахь байгууллагаас шаардан авна.

14. Хянан байцаах тасаг нь шалгалт явуулж байгаа үед зарим нэгэн асуудал дээр холбогдох мэрэгжлийн хүмүүсийг шалгалтын ажилд татан оролцуулах буюу үйлдвэрийн байр, склад агуулах зэргээр саадгүй орж үзэх эрхтэй.